НИЙСЛЭЛИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ,
ХӨГЖЛИЙН ГАЗАР

# 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН



УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

| Д/Д | ДЭД САЛБАР | ЗОРИЛТ | АРГА ХЭМЖЭЭ |
|---|---|---|---|
| 1. | Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | 10 | 41 |
| 2. | Хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг | 8 | 33 |
| 3. | Хуулиар нийтлэг олгосон чиг үүрэг | 1 | 16 |
| 4. | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах хүрээнд | 1 | 6 |
| | **НИЙТ** | **20** | **96** |

| д/д | Бодлогын баримт бичиг хууль, тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| 1 | ***Зорилго 1.*** *Улаанбаатарын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.* | | | | | | |
| 1.1 | ***Зорилт 1.*** *НЗДҮАХ –ийн 3.4.1.* Жуулчдыг татах ачлал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна. | | | | | | |
| 1.1.1 | 3.4.1. Гандангийн дэнж шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв боловсруулж, барилга угсралтын ажилд хамтран оролцоно. | 7,000.0 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | НИТХТ-ийн 2015 оны 98 дугаар тогтоол | 100 | - “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/ төслийн дагуу ажлын даалгаварт санал өгсөн.<br>- “Гандангийн дэнж” инженерийн шугам сүлжээний ажил” төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний “Кингс энд Инженеринг” ХХК-ний гүйцэтгэсэн шугам сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан. | 100 |
| 2 | ***6.1.*** *Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологи нэвтрүүлнэ.* | | | | | | |
| 2.1 | ***НЗДҮАХ –ийн* 6.1.1, *НХТЖҮЧ-ийн* 9.1.1, *НХЖТ-ний 6.1.1*** Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна. | | | | | | |
| 2.1.1 | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулах | 338.2 | УИХ-аар батлагдсан баримт бичгийн тоо | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал концепци батлагдсан. | 1 | - “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г Барилга, хот байгуулалтын Сайдын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжиж, Монгол Улсын Засгийн газарт өргөн барьж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Тус шийдвэртэй холбогдуулан материалын бүрдлийг хангуулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Үүнд:<br>✓ Улсын Их Хурлын тогтоолын төсөл;<br>✓ Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулга;<br>✓ Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал;<br>✓ Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага урьдчилсан тандан судалгааны тайлан;<br>✓ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн судалгааны тайлан; | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан;<br>- "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" Улсын Их хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Барилга, хот байгуулалтын Сайд, Хууль зүй, дотоод хэргийн Сайдаар батлуулсан бөгөөд одоогоор Засгийн газрын яамдаас Улсын Их Хурлын тогтоолын төсөлд санал авч байна. "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Улсын Их Хурлаар батлагдсаны дараа хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулна. | |
| 2.1.2 | Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг батлуулах | - | Бүсчлэлийн дүрэмд өгөх саналын тоо | Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийн төслийг боловсруулах суурь судалгаа хийгдсэн. | 2 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/113 дугаар захирамжаар Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсэг 2022 онд 3 удаа хуралдаж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран эрдэмтэн судлаачидтай уулзалт зохион байгуулж газрын төлбөрийн бүсчлэлийн талаар мэдээлэл солилцсон. 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар Нийслэлийн тэг гортиг бүхий эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлт, эдэлбэр газрын бүсчлэл, бүсчлэлийн дүрмийн төслийг боловсруулах ажлын талаар Улаанбаатар хотын Ерөнхий архитектор танилцуулга хийж, хурлын тэмдэглэлээр Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/-тай уялдуулахаар болсон. | 90 |
| 2.1.3 | Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад захиалагчийн хяналт тавих | - | Боловсруулсан ХЕТ-ний тоо | Ерөнхий төлөвлөгөө 26 ам | 5 ХЕТ | - Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/131 дүгээр захирамжийн дагуу "Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол" боловсруулах зургийн даалгаврыг боловсруулж, Нийслэлийн Засаг даргаар батлуулан Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Одоогоор худалдан авах ажиллагаа явагдаж байна.<br>- Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 19-р хорооны Хуурай мухар, 20-р хорооны Бэлхийн ам, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Чингэлтэй дүүргийн 19-р хорооны Шадивлангийн ам, Жигжидийн амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлыг "Ланд Овнер" ХХК гүйцэтгэж байна. Тус ажлын эхлэлийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 5 дугаар хурлаар, дундын тайланг 05 дугаар сарын 19-ний өдрийн 16 дугаар хурлаар хэлэлцүүлж, хүлээн авсан. Одоогоор эцсийн тайланд Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. | |
| 2.1.4 | Сонсголон, Амгалан, Шинэ төв дэд төвийн ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл боловсруулах | 425.0 | НИТХ-аар батлуулах баримт бичгийн тоо | - | 3 баримт бичиг боловсруулсан байна. | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дугаар захирамжийн дагуу Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд шинээр 3 дэд төв, байгуулах зураг төслийн ажлууд хийгдэж байна. Үүнд: "Амгалан", "Шинэ төв", "Сонсголон" дэд төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын эцсийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13 дугаар хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан. Одоогоор эцсийн тайланд Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. | 70 |
| 2.1.5 | Нисэх, Тахилт Дарь эх, Монель, Бичил, Ургах наран Хайлааст олон нийтийн төвүүдийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл боловсруулах | 619.7 | НИТХ-аар батлуулах баримт бичгийн тоо | - | 7 баримт бичиг боловсруулсан байна. | - Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/524 дүгээр захирамжийн дагуу Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд шинээр 7 олон нийтийн төвүүдийг байгуулах зураг төслийн ажлууд хийгдэж байна. "Монель", "Тахилт", "Дарь-Эх" олон нийтийн төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын дундын тайланг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан.<br>- "Нисэх", "Хайлааст", "Бичил", "Ургах наран", олон нийтийн төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын эцсийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 16 дугаар хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан. | 70 |
| 2.2 | ***НЗДҮАХ –ийн* 6.1.2, *НХТЖҮЧ-ийн 9.2.1* .** Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж, хотын хэт төвлөрлийг бууруулна. | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.1 | "Яармаг" хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөөг /Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлэх | - | Шинэчлэн боловсруулсан ХЕТ-ний тоо | НИТХТ-ийн 2015 оны 198 дугаар тогтоол | 1 | Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/651 дүгээр захирамжийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Сонголт дизайн" ХХК-тай байгуулсан гэрээгээр гүйцэтгэж буй Улаанбаатар хотын төлөвлөлтийн "27 дугаар нэгж хороолол"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.<br>Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 10 дугаар хурлын санал, дүгнэлтийг үндэслэн Улаанбаатар хотын төлөвлөлтийн 27 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах Зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хүртэл сунгахаар гэрээний төслийг боловсруулан холбогдох баримт бичгийг 2022 оны 02/1842 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 40 |
| 2.3 | ***НЗДҮАХ –ийн* 6.1.3, *НХТЖҮЧ-ийн 9.3,* НХЖТ-ний 6.1.8.** Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 2.3.1 | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох | 200.0 | Геопортал, гар утасны аппликейшн нэвтрүүлсэн тоо | Цахимжуулсан 11 төрийн үйлчилгээ | Геопортал, гар утасны аппликейшн нэвтрүүлсэн байна. | - Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжийн дагуу "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох" ажлын даалгаврыг боловсруулж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулан, шалгарсан Смартдата ХХК-тай 2022 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Гэрээний дагуу компанийн албан хаагчидтай уулзалт хийж, байгууллагын хэмжээнд ашиглаж буй одоогийн систем, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - мэдээллийн сангийн талаар танилцуулж, геопорталын загварын саналыг хүргүүлж, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүрд өгч хамтран ажиллаж байна. | |
| 2.3.2 | Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн “Улсын хаягийн нэгдсэн систем”-д бүрэн холбох | 184.0 | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Улсын хаягийн нэгдсэн системд холбох ажил 20%тай | 100 | Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2022 оны А/170 дугаар захирамжийн дагуу "Нийслэлийн хаягийн мэдээллийн санг шинэчлэн, Улсын хаягийн нэгдсэн системд холбох” ажлын даалгаврыг боловсруулж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалтын ажлыг зохион байгуулан, шалгарсан “Ай Си Ти групп” ХХК- тай 2022 оны 5 сарын 9-ний өдөр Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулагдсан. Гэрээний дагуу компанийн албан хаагчидтай уулзалт хийж, одоо ашиглаж байгаа нийслэлийн хаягийн мэдээллийн сангийн бүтэц, загвар, үйл ажиллагааны талаар танилцуулсан. Гүйцэтгэгч компани нь Улсын хаягийн системтэй холбоход зайлшгүй шаардлагатай системийн өгөгдлийн бааз, холболт, программ хангамжийн суурь судалгааг хийж байна. | 90 |
| 2.4 | ***НЗДҮАХ –ийн* 6.1.9, *НХТЖҮЧ-ийн 9.8.*** Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулж, нийтийн зориулалттай орон сууцыг засварлан иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах эрхийг хангана. | | | | | | |
| 2.4.1 | 6.1.9.1. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн | 14,876 .5 Улс, | Ажлын зураг төсөл | 18 багц байршилд | 2 | - Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлыг зураг төсөл, барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх | нийсл эл | зөвшилцсөн тоо | гадна инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний угсралт хийгдсэн. | | сүлжээний ажлын зураг төслийг **1 байршилд** зөвшилцсөн.<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл **2 байршилд** зөвшилцсөн.<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барилгажуулахад **10** байршилд барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгосон. Үүнд:<br>✓ Нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулгаж барих барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ **5** байршилд,<br>✓ Гадна усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээг **3** байршилд,<br>✓ Цахилгаан хангамжийн ажлын зөвшөөрлийн гэрчилгээ **2** байршилд. | |
| 2.4.2 | 6.1.9.2. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа, загвар зураг төслийг боловсруулах | - | Боловсруулсан судалгааны тоо | 2040 оны суурь судалгаа | 1 | -Сүхбаатар дүүргийн Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах СБД-11, СБД-12 багцын төслийн сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, Газрын даргаар батлуулсан. Сонгон шалгаруулалтын 16 багцын баримт бичгийг аж, ахуйн нэгжид цахим хаягаар хүргүүлж ажилласан. Үнэлгээний хороо 1 удаа хуралдаж ХУД-09 багцад "Нутгийн буян групп" ХХК шалгарсан. 2022 оны байдлаар бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэнтэй холбоотой ажлын хэсгийн хурал удаашралтай байна. Цаашид зорилтот түвшинд хүргэх зорилт тавин ажиллаж байна.<br>-Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 1-48, 2-48, 4-48, 3-20 дугаар байр, Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх ХАА-27 дугаар байр, Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо хорооны нутаг дэвсгэр дэх 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байр зэрэг Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 1175 өрхийн орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах, орон сууцыг | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орон сууцаар солих замаар чөлөөлөх, чөлөөлсөн талбайд түрээсийн орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зохион байгуулан ажиллахыг "Нийслэлийн Орон сууцны корпораци" ХК-д шилжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/498 дугаар захирамжаар батлуулсан.<br>-Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны 53 дугаар байрыг буулган шинэчлэн барилгажуулах эрх олгогдсон "Элит констракшн" ХХК, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 21, 22 дугаар байрыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгч "Уран проект" ХХК, Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны 30 дугаар байрыг буулган шинэчлэн барилгажуулах эрх олгогдсон "Вишн девелопмент" ХХК, Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны нэхмэлийн 3, 4, 8, 9 дүгээр байрыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгч "Эм жи капитал" ХХК-ийн танилцуулгыг бэлтгэн үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан баталгаажуулж ажилласан.<br>-Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинэчлэн барилгажуулах ажлын явцын танилцуулга, цаашид боловсруулах шаардлагатай төсөл, төлөвлөгөө, зураг төслийн ажлын танилцуулга, шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоог бэлтгэн Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хурлаар танилцуулав. Хурлын тэмдэглэлд хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх үүргийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт даалгасан бөгөөд манай газраас төсвийн хөрөнгө хүсэх тухай албан бичгийг холбогдох тооцооны хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.5 | **ЗГҮАХ-ийн 3.7.3, *НХТЖҮЧ-ийн 9.9.1,* НЗДҮАХ-ийн 6.1.11**. Барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийж, хүчитгэлийн зураг боловсруулж, лаборатори байгуулна. | | | | | | |
| 2.5.1 | 6.1.11.1. 2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг үргэлжлүүлэх, | 565.0 | Паспортжуулсан барилгын тоо | Паспортжуулсан барилга 840 | 984 /144 барилга нэмж паспортжуулсан байна/ | - Газрын даргаар 2022 онд паспортжуулах 172 барилгын жагсаалт, төсвийн задаргааг батлуулав. Нийслэлийн Засаг даргын 2022 оны "А/171 дүгээр захирамжийн дагуу 172 барилгын бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах 5 багц ажил тендерийг 2022 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн 2 удаа зарлаж,1 аж ахуй нэгж үнийн санал ирүүлсэн болович тендерийн баримт бичгийн иж бүрдэл дутуу, шаардлага хангаагүй учир тендер амжилтгүй болсон. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 01/2087 дугаар албан бичгийн дагуу төсвийн тодотгол хийж дуусах хүртэл сонгон шалгаруулалтыг түр хугацаагаар зогсоосон.<br>- 36 барилгад хэмжилт судалгаа хийж, 31 барилгад паспортжуулалтын мэргэжлийн дүгнэлтийг гаргасан. | 30 |
| 2.5.2 | 6.1.11.2. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, стандартын шаардлага хангасан амины орон сууцны нэг маягийн загвар зураг боловсруулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх санал хүргүүлэх | 100.0 | Хүчитгэл хийх шаардлагатай барилгын судалгаа | JICA судалгаа | 1 | Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, чадавхыг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шатны ажил эхлэхтэй холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Япон Улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын төлөөлөлтэй уулзаж барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин, бодлого, норм дүрэм, хүчитгэх үйл ажиллагаа, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх талаар санал солилцов. | 30 |
| | | | Нэг маягийн зургийн тоо | - | 10 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/554 дүгээр захирамжаар Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн 10 төрлийн загвар зураг, ажлын зураг төсөл боловсруулах ажилд 100,0 сая төгрөг батлагдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сонгон шалгаруулалт зохион байгуулахад шаардлагатай Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн ажлын даалгаврыг боловсруулан Нийслэлийн Ерөнхий архитектороар батлуулан Нийслэлийн Худалдан авах, ажиллагааны газарт хүргүүлсэн. Нийслэлийн Худалдан, авах ажиллагааны газраас худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2022 оны 01/2087 дугаар албан бичгийн дагуу төсвийн тодотгол хийж дуусах хүртэл сонгон шалгаруулалтыг түр хугацаагаар зогсоосон. | 30 |
| 2.6 | **НЗДҮАХ-ийн 6.1.8** ***НХТЖҮЧ-ийн 9.7.1, 9.7.2, 9.7.3*** *Түрээсийн олон төрөлт болон оршин суугчдын орлогод нийцсэн ногоон орон сууцны шинэ хорооллуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.* | | | | | | |
| 2.6.1 | “Залуус-1” орон сууцны хорооллын төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ, барилга байгууламж, авто замын ажлыг эхлүүлэх | - | Инженерийн шугам сүлжээний зураг төсөл зөвшилцсөн байдал | Инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажил боловсруулж эхэлсэн. | 100 | - Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар хэрэгжиж буй “Залуус-1” орон сууцны хороолол нь 57.0 га нэгж талбайд 5616 айл өрхийн 24,398 хүн амтай төлөвлөгдсөн. Тус төслийн эхний ээлжийн барилга байгууламж нь 13 дугаар магистраль, төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээнээс тэжээгдэхээр 7.5 Гкал/цаг-ийн техникийн нөхцөл олгогдсоны дагуу 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ, 80 Гкал/цаг-ийн хүчин чадалтай дулааны эх үүсвэрээс хангагдах дулаан хуваарилах төв, төвлөрсөн дулааны сүлжээтэй хосолмол ажиллагаатай ажиллах гадна дулааны шугам сүлжээний ажлын зураг төсөл, цахилгаан хангамжийн 110/35/10 кВ-ын дэд станц, 110 кВ-ын ЦДАШ-ын трасс, 10 кВ-ын кабель шугам, хуваарилах байгууламж, хаалттай дэд өртөөний барилгын зураг төсөл, 2x1000м3 усан сан, ус хангамж, ариутгах татуурга, гадна дулааны шугам, инженерийн бэлтгэл арга хэмжээ, холбоо мэдээллийн худаг сувагчлалын ажлын зураг төсөл зөвшилцсөн.<br>- Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар эхний ээлжийн барилгажилтын төслийг хангах шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажил эхэлсэн. | 100 |
| 3 | *Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж тус орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.* | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1 | ***ЗГҮАХ-ийн 3.7.4, НЗДҮАХ-ийн* 6.2.1.** Дагуул хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна. | | | | | | |
| 3.1.1 | 6.2.1. Дагуул хот байгуулах нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршлыг УИХ-аар батлуулна. | - | Саналын тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсанаар Дагуул хот байгуулах нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил тодорхой болно. *Хэрэгжилтийн хугацаа болоогүй.* | - |
| 3.1.2 | 6.2.3. Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс байгуулах газар нутгийн хэмжээ байршлыг тогтоож, Засгийн газраар батлуулна. | - | Саналын тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсанаар Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүс байгуулах газар нутгийн хэмжээ, байршил тодорхой болно. *Хэрэгжилтийн хугацаа болоогүй.* | - |
| 3.1.3 | 6.2.4. Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, батлуулах | - | Ажлын даалгаврын тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | - Нийслэлийн дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газраас гаргасан хөтөлбөрийн дагуу 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах газрын байршилтай танилцан, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Туушин логистикийн төсөл, Майдар хот төсөл, Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал болон ойр орчмын бүтээн байгуулалт, Эмээлт эко аж үйлдвэрийн парк, Монгол наадам цогцолборын үйл ажиллагаатай танилцсан. | 30 |
| 3.1.4 | 6.2.1.1. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл", Бүсийн хөгжлийн хөтөлбөртэй Нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулах | - | Саналын тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах ажилтай холбогдуулан шаардлагатай мэдээ, мэдээллээр тухай бүр хангаж, төслийн үе шатны тайланд санал өгч, холбогдох хэлэлцүүлэгт оролцож ажиллахаар тусгагдсан. Тус ажлын хүрээнд "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах ажлын явц, үе шатны тайлан мэдээллийг ирүүлэх тухай Нийслэлийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 01/1030 дугаартай албан бичгийг Барилга, хот байгуулалтын Сайдад хүргүүлсэн. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.5 | 6.2.1.2. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 11 дагуул хот, тосгодын ХЕТ батлагдсан. | 3 /Жаргалант, Рашаант, 361 гарам/ | Улаанбаатар хотын Жаргалант, Рашаант, 361 гарам, Өлзийт дагуул тосгодын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай хөрөнгийг Нийслэлийн 2022 оны төсвийн "Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ" боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 0 |
| 3.1.6 | 6.2.1.3. "Шинэ зуун мод", "Майдар" шинэ дагуул хотын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэст өөрчлөлт оруулах санал боловсруулах | - | Саналын тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | ""Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г Монгол Улсын Засгийн газраар хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их хуралд өргөн барихаар ажиллаж байна. Тус хөгжлийн ерөнхий төлөвлөгөө Улсын Их хурлаар батлагдсаны дараа ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн санал боловсруулна. | 0 |
| 3.1.7 | 6.2.1.4. Богдхан уулыг тойрсон "Хөгжлийн алтан тойрог" байгуулах, ТЭЗҮ, боловсруулах | - | Ажлын даалгаврын тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | Нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2021 онд албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Нийслэлийн 2022 оны төсөвт тусгагдсан "Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ" боловсруулах хөрөнгөөс шийдвэрлэх саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 02/325 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 0 |
| 3.1.8 | 6.2.7. Ачаа тээврийн логистик төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна. | - | Ажлын даалгаврын тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | Ачаа тээврийн логистик төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 02/325 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч 2022 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаагүй. | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.9 | 6.2.1.6. “Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах | - | ТЭЗҮ, ХЕТ тоо | - | 1 | Барилгын материалын бөөний худалдааны төвийн техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 02/325 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч 2022 оны нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтад тусгагдаагүй. | 0 |
| 3.1.10 | 6.2.1.7. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагыг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхлэх | 120.0 | Ажлын даалгаврын тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагыг хотоос шилжүүлэх бодлого боловсруулах зөвлөх үйлчилгээний хөрөнгийг нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулахаар 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 02/325 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй . | 0 |
| 3.1.11 | 6.2.1.8. Зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлж эхлэх | - | Санал боловсруулж, танилцуулсан тоо | УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепци/ | 1 | Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зарим их дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотуудад шилжүүлэх судалгаа болон төлөвлөлтийн шийдлийг тусгаж ажилласан. | 30 |
| 4 | ***6.3.**Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.* | | | | | | |
| 4.1 | ***НЗДҮАХ-ийн* 6.3.21.** Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ. | | | | | | |
| 4.1.1 | Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ. | - | Ажлын зураг зөвшилцсөн байдал | - | 100 | - Хан-Уул дүүргийн 8, 21 дүгээр хороо, Жаргалантын амны үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг 2022 оны Мэргэжлийн зөвлөлийн 03 дугаар хурлын шийдвэрээр хэлэлцүүлэн батлуулсан. Ажлын зураг төслийн даалгаврыг ГУББГ ОНӨААТҮГ, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т тус тус хүргүүлсэн.<br>- Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/281 дүгээр захирамжаар зураг төсөл, барилга угсралтын ажлын **3,6 тэрбум төгрөгийн** хөрөнгө шийдвэрлэгдэн, Худалдан | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авах ажиллагааны газраас сонгон шалгаруулалт зарлагдсан. | |
| 4.2 | ***НЗДҮАХ-ийн*** **6.3.24.** Ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр барина. | | | | | | |
| 4.2.1 | 6.3.6."Буянт-Ухаа 2" хороолол орчимд барих усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ. | - | Усан сан, цэвэр усны шугамын ажлын зураг төсөл боловсруулагдана. | - | Усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. | Нийслэлийн 2022 оны төсвийн тодотголд хөрөнгийг тусгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 08/1803 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | 30 |
| 4.2.2 | 6.3.7.Толгойт, их наран орчимд барих усан сан, шугам сүлжээний барилга, угсралтын ажлыг эхлүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Ажлын зураг төсөл батлагдсан. | Усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх. | - Тус ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 4 хороо Их нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф400мм-ийн голчтой 2,8 км шугамын ажил хийгдэж дууссан.<br>- 2х500 м3 усан сангийн барилгажилтын ажил, цэвэр усны цагариг шугам сүлжээний ф150/ф250 мм-ийн 7.8км шугамын ажил хийгдсэн.<br>- Цэвэр усны шугамын ажлын зураг төслийг "Хайдродизайн инноваци" ХХК боловсруулан баталгаажуулсан. | 100 |
| 4.2.3 | 6.3.11."Буянт-Ухаа 2" хороолол орчмын ариутгах татуургын гол шугамын 2 дугаар ээлжийн ажлыг үргэлжлүүлэх | 500.0 Улсын төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Ажлын зураг төсөл батлагдсан. | Ф500/600 мм голчтой шугамын барилга угсралтын ажлыг 30 хувьд хүргэнэ. | "Буянт ухаа -2" хорооллын II дугаар ээлжийн барилгажилтын төслийн ариутгах татуургын шугамын 3 дугаар хэсгийн шугамын трассыг Солонго хорооллын барилгажилтын төсөлтэй уялдуулах ажлын зургийн өөрчлөлтийг гүйцэтгэж буй "Түвшинжин" ХХК-д зөвлөмж хүргүүлж мэдээллээр хангаж ажиллав. | 70 |
| 4.2.4 | 6.3.12. Дарь эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлэх | 2,000.0 Улсын төсөв | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Ажлын зураг төсөл батлагдсан. | Ф300/400 мм голчтой шугамын барилга угсралтын ажлыг | - Дарь эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын Ф300мм-ийн хүчин чадалтай 4.8км ариутгах татуургын шугамын ажлын зураг төслийг зөвшилцөн, трассыг мэдээллийн санд оруулсан.<br>- Тус шугамын барилга угсралтын ажлын санхүүжилт хэсэгчлэн шийдвэрлэгдсэн бөгөөд барилга угсралтын ажил эхлээгүй байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эхлүүлсэн байна. | | |
| 4.2.5 | 6.3.13.Зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлын зураг төслийг боловсруулах | 500.0 Улсын төсөв | Ажлын зураг зөвшилцсөн тоо | - | 1 багц ажлын зураг төсөл батлагдсан байна. | Тус ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 24, 25 дугаар хорооны нутаг дэвсгэрт 5 байршлын ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 22 дугаар хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. | 70 |
| 4.2.6 | 6.3.18. Чингэлтэй дүүргийн Сервис центрийн бохирын цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрөм байгуулна. | 1,000.0 Улсын төсөв | Ажлын зураг зөвшилцсөн тоо | - | 1 | Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 01 дүгээр хурлын шийдвэрээр Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо, Сервис центрийн бохирын цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрмийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг батлуулан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. | 100 |
| 4.2.7 | 6.3.19. Шинэ суурьшлын бүс болон гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах шугам, дэд станц барьж цахилгаан хангамжийг сайжруулна. | 11,816.8 Улсын төсөв | Ажлын зураг зөвшилцсөн тоо | 1233, дэд өртөө | 4 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Шинэ суурьшлын бүс болон гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах, шугам дэд станц барьж, шугам сүлжээний найдвартай ажиллагааг сайжруулах 101 байршлын ажлын зураг төсвийг зөвшилцсөн. | 100 |
| 4.2.8 | 6.3.22. Сэлбэ дэд төвийн дулааны эх үүсвэрийг ашиглалтад оруулж, Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвүүдийн дулааны эх үүсвэрийн ажлын зураг төслийг бүрэн дуусгана. | - | Ажлын зураг зөвшилцсөн тоо | Сэлбэ дулааны станцын ашиглалтын туршилт, тохируулгын ажил хийж байна. | 2 | **Сэлбэ дэд төвийн дулааны эх үүсвэр** нь 2022 онд ажиллагаанд залгагдсан бөгөөд тус дулааны эх үүсвэрээс 29 аж ахуйн нэгж, байгууллага төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдсон. Сэлбэ дэд төвийн дэд бүтэц, гадна инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалт нь 99,3%-ийн гүйцэтгэлтэй байна. **Дамбадаржаа дэд төвийн 63 МВт хатуу түлшний дулааны эх үүсвэрийн** техник эдийн засгийн үндэслэл нь Эрчим хүчний яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар хурлын тэмдэглэлээр батлагдсан. Ажлын зураг төсөл зөвшилцөж, магадлал хийгдсэн. Газар чөлөөлөлтийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр 76 тэрбум төгрөг шийдвэрлэгдээгүй байна. Дамбадаржаа дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцсөн. **Дэнжийн 1000 дэд төвийн 80Гкал/цаг-ийн хий хангамжийн эх үүсвэрийн** техник, эдийн засгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үндэслэл, ажлын зураг төсөл батлагдсан. Эх үүсвэрийн барилга угсралтын ажилд шаардлагатай 10 сая долларын гэрээ Азийн хөгжлийн банкны төслөөр хэрэгжүүлэхээр батлагдсан. | |
| 4.2.9 | 6.3.23. Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д ф800мм-ийн гол шугамыг ф1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3,4 км/ Сонгинохайрхан дүүрэг ажлыг үргэлжлүүлнэ. | 2,000.0 Улсын төсөв | Ажлын зураг зөвшилцсөн шугамын урт, км | 3,4км | ф800мм-ийг ф1000 мм голчтой болгон өргөтгөнө | - Нийслэлийн 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх 11г,д ф800мм-ийн гол шугамыг ф1000мм голчтой болгон өргөтгөх 0,716 хос.км дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн.<br>- Нийслэлийн 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Дулааны шугамын трасс дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлэн тусгуулсан. | 100 |
| 4.2.10 | 6.3.24. Дулааны цахилгаан станц 4-өөс у-18 хүртэлх/ Москва хорооллын урд тал хүртэл/ 4,2 км, ф800-ийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх | 1,800.0 Улсын төсөв | Ажлын зураг зөвшилцсөн шугамын урт, км | - | 4,2 км | - Дулааны цахилгаан станц 4-өөс у-18 хүртэлх/ Москва хорооллын урд тал хүртэл/ 4,2 км, ф800-ийн голчтой дулааны шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн. Тус шугамын бүтээн байгуулалтын ажил 64%-тай хийгдэж байна.<br>• Нийслэлийн Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд дулааны шугамын трасс дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлэн тусгуулсан. | 100 |
| 4.2.11 | 6.3.25.2а, 4а,4б,10в, 10г, 10д магистраль шугамын дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх | 16,170.0 Гадаадын зээл тусламж | Ажлын зураг зөвшилцсөн шугамын урт, км | 7,55 км шугам | 2,7 км дулааны шугамын угсралтын ажил хэрэгжүүлсэн байна. | - Дэлхийн банкны санхүүжилтээр 4а магистраль ДХ408-р цэгээс ДХ-435-р цэг хүртэлх 2ф250/350мм голчтой 1.1 хос.км шугамыг 2ф700мм голчтой болгон өргөтгөн шинэчлэх ажлын 6,9 тэрбум.төгрөгөөр хийхээр төлөвлөгдсөн.<br>- Барилга, хот байгуулалтын яамны санхүүжилтээр 10в,г, д магистраль шугамын ажлын зураг төслийг "Эрчим төсөл" ХХК гүйцэтгэсэн бөгөөд манай байгууллагатай урьдчилсан байдлаар зөвшилцөж, санал зөвлөмж хүргүүлсэн.<br>- Нийслэлийн Газар зохион байгуулалтын 2022 оны төлөвлөгөөнд 4а, б, 2в, 10в,г,д магистраль шугамын дулааны шугамын трассын дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлэн тусгуулсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.12 | 6.3.26.БЗД-ийн 10 дугаар хороо, Төмөр замын 2-р анги Амгалан орчмыг хангах дулааны шугам шинээр татах | 330.0 Гадаадын зээл тусламж | Ажлын зураг зөвшилцсөн шугамын урт, км | - | 2,2 хос км шинээр хийгдсэн байна. | - Төвлөрсөн дулаан хангамжийн БЗД-ийн 10 дугаар хороо, Төмөр замын 2-р анги Амгалан орчмыг хангах дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн.<br>- Нийслэлийн 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дулааны шугамын трасс дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлэн тусгуулсан. | 100 |
| 4.2.13 | 6.3.27.Шинээр 240 гкал/ цаг-ийн дулааны ачаалал бүхий дахин төлөвлөлтийн бичил VI хорооллуудыг дулааны эрчим хүчээр хангах боломжийг бүрдүүлэх | 2,200.0 Гадаадын зээл тусламж | Ажлын зураг зөвшилцсөн шугамын урт, км | - | 0,695 км | - Төвлөрсөн дулаан хангамжийн VII хорооллуудыг дулааны эрчим хүчээр хангах 2ф400 хос.км дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн.<br>- Нийслэлийн 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Дулааны шугамын трасс дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлэн тусгуулсан. | 100 |
| 4.2.14 | 6.3.1. Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний ажлын явцад хяналт тавьж ажиллах | - | Төлөвлөгөө 1 | - | Инженерийн бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна. | Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулах ажлын дундын тайланг Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 19 дүгээр хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан. Мэргэжлийн зөвлөлийн хурлаас гарсан санал, зөвлөмжийг эцсийн тайланд тусгуулахаар Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв, Престиж инженеринг ХХК-д 2022 оны 08/2307 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | 70 |
| ***ХОЁР . ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| *Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд:* | | | | | | | |
| 2.1 | Газрын стратеги төлөвлөгөөний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Газрын 2021-2024 оны Стратеги төлөвлөгөө"-ний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг жилийн эцсээр нэгтгэн дүгнэнэ. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2 | НИТХ-ын 2014 оны 5/14 дүгээр тогтоолоор баталсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилгын угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэн батлуулах | - | - | 1 | 1 | Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Хуулиар тусгайлан зохицуулаагүй асуудлыг нийслэл хотын дүрмээр зохицуулж болно." гэж заасны дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран "Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга байгууламжийн үе шатны зөвшөөрөл олгох, барилга барих үйл ажиллагааны дүрэм"-ийн төслийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Нийслэл хотын багц дүрэмд оруулан батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 70 |
| 2.3 | Барилга байгууламжийг паспортжуулсан дүгнэлтийг бүрэн цахимжуулах | - | Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэсэн барилгын тоо | 840 | 984 | 2022 оны хагас жилийн байдлаар 2021 онд паспортжуулсан 15 барилгыг мэдээллийн санд бүртгэв. | 30 |
| 2.4 | Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд оролцож Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийн дагуу барилгын ажил гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавьж санал өгөх; | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хүрээнд 121 барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, санал өгч ажилласан. | 100 |
| *Нийслэлийн хэмжээнд хот төлөвлөлтийн чиглэлээр тулгамдаж буй асуудлаар судалгаа хийх, төсөл хөтөлбөр боловсруулах, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, чанар, үр дүнг тодорхойлох* | | | | | | | |
| 2.5 | Хүй долоо худаг дахь "Монгол наадам цогцолбор"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулж Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулна. | - | Батлагдсан хот байгуулалтын баримт бичгийн тоо | ЗГ-ын 2016 оны 225 тогтоол | 1 | Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар Хүй долоо худаг дахь "Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"-г хэлэлцүүлж, "Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 99 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | Багахангай дүүргийн "Хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк"-ийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлуулах | - | НИТХТ-ийн тогтоол | Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийгдсэн | 1 | Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/528 дугаар захирамжийн дагуу "Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл" боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчээр "Аесн" ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Барилга, хот байгуулалтын Сайдын 2021 оны 241 дүгээр тушаалаар орон тооны бус экспертүүд томилогдож "Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл"-ийг хянан үзэж, 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 140/2022 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлт гарсан. "Багахангай дүүргийн Үйлдвэрлэл, технологийн паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл"-ийг эцэслэн батлуулахаар Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурал, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг бэлтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 90 |
| *Барилга, хот байгуулалтын үйл ажиллагааг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:* | | | | | | | |
| 2.7 | Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн барилга, байгууламжийн архитектур төлөвлөлтийн даалгавар батлах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн Ерөнхий архитекторын хуулиар тусгайлан олгосон эрх үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн барилга барих хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлийн 19 удаагийн хурлын шийдвэрээр 641 архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. | 100 |
| 2.8 | Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн нийтийн эдэлбэр газрын тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар батлах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийтийн эдэлбэр газрын 219 байршилд тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгавар хянан баталсан. | 100 |
| 2.9 | Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн авто зам, замын байгууламжийн төлөвлөлтийн даалгавар батлах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - 2022 оны хагас жилийн байдлаар 74 авто зам, замын байгууламж төлөвлөх даалгаврыг хянан баталсан. Үүнд:<br>✓ Авто зам, замын байгууламж 69<br>✓ Гүүрэн байгууламжийн 4 авто зам, замын байгууламж. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.10 | Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн хөшөө, дурсгал хүндэтгэлийн самбар байршуулах ажлыг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 дугаар "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, Нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай" тогтоолын дагуу хийгдсэн Нийслэлийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр тус чиг үүрэг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд шилжсэн.<br>Тайлант хугацаанд хөшөө байгуулах талаар 1 хүсэлт ирүүлснийг Захирагчийн ажлын албанд шилжүүлсэн. | - |
| 2.11 | Холбогдох хууль журам, норм ба дүрмийг үндэслэн нийтийн эдэлбэр газрыг дахин төлөвлөн зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/388 дугаар захирамжийн дагуу **188** байршилд гарааш буулгаж, газар чөлөөлсөн байршилд **5 бүлгээр** судалгааг боловсруулж **100 хувь шийдэл** гаргаж, Ажлын хэсгийн хуралд танилцуулан **79** байршилд төлөвлөлтийн даалгавар баталсан. | 100 |
| 2.12 | Барилга, байгууламж, тохижилт, авто зам, замын байгууламжийн загвар зураг батлах, хүчинтэй хугацааг шийдвэрлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | 2022 оны хагас жилийн байдлаар Барилга байгууламж, тохижилтын ажлын **241,** Авто замын 20, Замын байгууламжийн 4 загвар зураг хянаж батлуулсан. Үүнээс: **6** байршилд загвар зураг хүчинтэй эсэхийг хэлэлцүүлсэн. | 100 |
| *Хот байгуулалтын кадастрыг эрхлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:* | | | | | | | |
| 2.13 | Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, талбай, хотхон хорооллыг нэршүүлэх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулж, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02/01, Гал сөнөөгчдийн холбооны 2021 оны 130 дугаартай тус тус албан бичгээр Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Цэцэг төвийн уулзвараас ерөнхий боловсролын V дугаар сургууль хүртэлх Бага тойруугийн гудамжийг "Гал сөнөөгчдийн гудамж" гэж өөрчлөн нэршүүлэх хүсэлтийг ирүүлсэн. Хүсэлтийн дагуу шинээр бүтээн байгуулалт хийгдэж байгаа авто замыг нэршүүлэх боломжийг судлан танилцуулж, гудамжны нэр өөрчлөх боломжгүй хариуг 2022 оны 04/25 дугаартай албан бичгээр, гал унтраах аврах ангиудын байршил бүхий зургийн хамт хүргүүлсэн. Үүний дагуу ХУД-ийн 3 дугаар хороонд 2022 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх шинэ авто замыг барьж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглалтад оруулсны дараа нэршүүлэх ажлыг зохион байгуулна. | |
| 2.14 | Барилга байгууламжид хаяг дугаар олгох ажлыг хариуцан гүйцэтгэх | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв, e-mongolia.mn-ээр ирүүлсэн хаяг дугаар хүссэн 727 хүсэлтийг хүлээн авч 1051 барилгад шинээр, 132 барилгад дахин тодорхойлолт олгов. | 100 |
| 2.15 | Барилга байгууламжийн тэг тэнхлэгийн актыг мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэж Хот байгуулалтын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгөх **208** хүсэлтийн **487** блок барилга, байгууламжийг төлөвлөлтийн мэдээллийн санд бүртгэж, **165** актаар хүлээж авав. | 100 |
| 2.16 | Гүйцэтгэлийн байр зүйн зургийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээн авч бүртгэн мэдээллийн сангийн суурь өгөгдлийг шинэчлэх, баяжуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний байр зүйн зургийг мэдээллийн санд хүлээлгэн өгөх **902** хүсэлтийг хүлээн авч, хот байгуулалтын суурь өгөгдлийг **270.0 га** талбайгаар шинэчлэн баяжуулж, **596** акт үйлдсэн. | 100 |
| 2.17 | Хот байгуулалтын мэдээллийн сан дах зураг болон тоон мэдээ, мэдээллээр холбогдох журмын дагуу үйлчилгээ үзүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Цахилгаан дамжуулах Үндэсний сүлжээ ТӨХК, Дулааны сүлжээ ТӨХК, Ус сувгийн удирдах газар, Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Нийслэлийн Замын хөгжлийн газартай байгуулсан "Хот байгуулалт, хөгжлийн газрын албаны нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай" гэрээний дагуу 1:5000 масштабтай байр зүйн дэвсгэр зургийг (155 планшет), НХОГ-т 3х3 сагсан бөмбөгийн талбайн тохижилт хийх 14 байршлын байр зүйн зургийг тоон байдлаар хүргүүлсэн.<br>- Цагдаагийн Ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Монгол Улсын Харилцаа Холбооны зохицуулах хороо, Нийслэлийн Замын хөгжлийн газар, Хотын стандарт, хяналтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд "Газарзүйн мэдээлэл хүлээлгэн өгөх, солилцох, хамтран ажиллах" тухай гэрээг байгуулан нийт орон зайн 98 төрлийн мэдээллийг хүлээлгэн өгөв. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - НҮБ-ын Ази, номхон далайн бүсийн Эдийн засаг нийгмийн зөвлөлийн "Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг бодит болгох ажлын хүрээнд үндэсний түвшин боловсруулахад шаардлагатай суурь судалгаанд хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэлтэй Засгийн газрын 181ш барилгын мэдээллийг Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт өгсөн.<br>- Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв, E-mongolia.mn-ээр инженерийн шугам, сүлжээний зурган мэдээлэл авах 53 хүсэлтийг хүлээн авч, 72 байршилд байр зүйн зургийг иргэн, аж ахуйн нэгжид гаргаж өгсөн.<br>- Гамшгийн үед түр орон байраар хангах албанд 2.8х1.8м хэмжээтэй сэдэвчилсэн зураг 2 хувь, Сонгинохайрхан дүүргийн 30, 31, 43 дугаар хорооны сэдэвчилсэн зураг, Нийслэлийн Улсын бүртгэлийн газарт гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг, сургалтын үед хэрэглэх Улаанбаатар хотын 1.8мх2.8м хэмжээтэй ажлын зураг, НБИХГ-т Улаанбаатар хотын 1.8мх2м хэмжээтэй сэдэвчилсэн зургуудыг хүсэлт гаргасан иргэн, аж ахуй нэгжид тус тус бэлтгэн хэвлэж өгсөн. | 100 |
| 2.18 | Хот байгуулалтын мэдээллийн сан дах орон зайн дэд мэдээллийн сангийн өгөгдлийн шинэчлэх, баяжуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Шинээр хаяг дугаар авсан 1001 барилгын 25-69 төрлийн мэдээллээр барилгын дэд мэдээллийн санг баяжуулав.<br>- Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлагдсан Төлөвлөгдсөн барилгаас "Устгах" төлөвтэй нийт 222 барилгын мэдээллийг арилгаж, суурь мэдээллийг шинэчилсэн. */ХУД-151, СБД-15, ЧД-15, БГД-13, БЗД-11, Алс-2, СХД-15/*<br>- Байнгын ашиглалтад оруулах улсын комисс хүлээж авсан, давхарлаж оруулсан зэрэг нийт 2422 төлөвлөлтийн барилгын мэдээллийг устгаж, шинэчилсэн.<br>- Байр зүйн зургаар хүлээлгэн өгсөн 5.6 км авто зам, 11.8 км цахилгааны шугам, 28,8 км дулааны шугам, 6.5 км ариутгах татуурга, 9.1 км усан хангамжийн мэдээллээр дэд сангуудын өгөгдлийг шинэчлэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Дүүргийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын цэгэн мэдээллийг шинэчлэв.<br>- Хот байгуулалтын мэдээллийн санд байр зүйн зургаар хүлээлгэн өгсөн 49.3 км авто зам, 66.3 км цахилгааны шугам, 36.2 км дулааны шугам, 19.1 км ариутгах татуурга, 20.1 км усан хангамж, 7,8 км холбооны шугамын мэдээллээр дэд сангуудын өгөгдлийг шинэчлэв. Цахилгаан дамжуулах Үндэсний сүлжээ ТӨХК-аас ирүүлсэн албан бичгийн дагуу Их тойруу 110кВ-ын ЦДАШ-ын Дүнжингарав дэд станцаас Сонгино дэд станц хүртэлх хэсгийн хамгаалалтын зурвасыг шинэчлэв.<br>- Хан-Уул дүүргийн хороодын заагийн өөрчлөлтийн мэдээллээр хороодын нутаг дэвсгэрийн дэд мэдээллийн санг шинэчлэв.<br>- Хот байгуулалтын мэдээллийн сан дахь цэцэрлэг, шатахуун түгээх станц, зах, худалдааны төв, худалдаа үйлчилгээний төвийн мэдээллийг шинэчлэв.<br>- Тэрэлж тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хил, төлөвлөсөн авто замын мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд оруулсан. | |
| 2.19 | Байгууллагын гадаад болон дотоод сүлжээний зохион байгуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, сервер, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, хот байгуулалтын мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, нөөцлөх ажлыг зохион байгуулах | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг Дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтний хамт акт үйлдэн устгаж, Нийслэлийн Засаг даргын тамгын газарт албан бичгээр актыг хүргүүлэв.<br>- Газрын дотоод сүлжээнд шинээр томилогдсон 19, ажлаас чөлөөлөгдсөн 15 албан хаагчдын нэвтрэх, хандах эрхийг тогтоосон.<br>- Шинээр байгуулагдсан 2 нэгжийн дотоод сүлжээ болон цахим баримт бичгийн хавтсыг нээж, хандах эрхийг тохируулав.<br>- Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолын дагуу мэдээллийн аюулгүй байдлыг Фортинэт загварын галт хана болон домайн контроллер дээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвшөөрөлгүй вэб хуудас болон зөвшөөрөлгүй программуудыг хязгаарлах арга хэмжээ авч ажиллав.<br>- Цаг бүртгэлийн машинаас албан хаагчдын мэдээллийг өдөр бүр татаж UB.ERP системд оруулав. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/217 дугаар захирамжийн дагуу нийт албан хаагчдын цаг бүртгэлийг шинэчлэв.<br>- Байгууллагын цахим баримт бичгийн 11ТВ хэмжээтэй серверийн багтаамж дүүрсэнтэй холбоотой нэгжүүдийн дотоод ажлын хавтсыг өөр сервер лүү шилжүүлж 6ТВ хэмжээг цэгцлэв.<br>- Мэдээллийн аюулгүй байдлын газарт төрийн нэгдсэн сүлжээнд холбогдох хүсэлтээ албан бичгээр хүргүүлж, холбогдох тоног төхөөрөмж, сэлбэгийг бэлтгэж байна. | |
| 2.20 | Хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн сангийн өгөгдлийн баазыг шинэчлэх, хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Системийн өгөгдөл мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчлэн ажиллаж байгаа бөгөөд домэйн болон давхаргын шинэчлэлт:<br>✓ Хот байгуулалтын төлөвлөлт давхаргын LRT трасс<br>✓ Хэлтсүүдийн үйл ажиллагааны хил хуваалт<br>✓ Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө дэд давхаргын Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл<br>✓ Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хил хязгаар<br>✓ Бүх прожектэд Барилгажихыг хориглосон бүс, Хүн амын нягтрал хэтэрсэн байршил зэрэг дэд давхаргуудыг устгасан.<br>✓ Хаягийн бүс домэйнд сонголтын утгуудыг цэгцэлсэн<br>✓ Байгууллагын шинэ бүтэц зохион байгуулалттай холбоотойгоор хэвлэх дэд программын загваруудыг шинэчилсэн.<br>Дэд программ хангамжийн шинэчлэлт, өгөгдлийн баазын хадгалалт хамгаалалт:<br>✓ Хот байгуулалтын менежментийн систем болон түүнтэй холбогдон ажилладаг бусад дэд программ хангамжуудын өгөгдлийн 9 бааз, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим хуудас болох uda.ub.gov.mn өгөгдлийн баазыг тус тус нөөцөлсөн.<br>✓ "Цахим бүртгэлийн програм" хангамжийг хот байгуулалтын мэдээллийн системд холбон үйл ажиллагаанд хэрэглэхэд бэлэн болсон.<br>✓ Хот байгуулалтын менежментийн системийн барилга байгууламжийн мэдээллийн санд бүртгэгдсэн өгөгдлийг PostgreSQL/QGIS хөрвүүлж нээлттэй эх үүсвэрийн OpenLayer, GeoServer ашиглан зөвшөөрөлтэй барилгын мэдээллийг http://202.179.30.179/ebarilga/ геопортал хийж мөн зөвшөөрөлгүй барилгын мэдээллийг илгээх санал хүсэлтийн модуль үүсгэн тестлэх үйл явц хийгдэж байна.<br>✓ Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирсэн албан бичиг, материалыг хялбар шуурхай олох зорилгоор хэн гэдэг мэргэжилтэн дээр ирсэн, явцын мэдээллийг харах зорилгоор http://202.179.30.179/edocs/ вэб программ хангамжийг боловсруулж байна. | |
| 2.21 | Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг тогтмол хийх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, мэдээ мэдээллийг шинэчлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Тайлант хугацаанд байгууллагын http://uda.un.gov.mn цахим хуудсанд 12 төрлийн 120 мэдээ мэдээллийг шинэчлэн байршуулсан. Үүнд:<br>✓ Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ – 1<br>✓ Үйл ажиллагааны төлөвлөгөө – 10<br>✓ Санхүүгийн мэдээ – 10<br>✓ Мэргэжлийн зөвлөлийн хурлын мэдээ – 38<br>✓ Барилгын ажлын зөвшөөлийн гэрчилгээ олгосон мэдээ – 10<br>✓ Цаг үеийн мэдээ – 10<br>✓ Хүний нөөцийн мэдээ – 6<br>✓ Бүтэц, зохион байгуулалтын мэдээ – 11<br>✓ Тендерийн урилга – 2<br>✓ Ирсэн, явсан бичгийн мэдээ – 4<br>✓ Үйлчилгээний бүрдүүлэх материал – 23<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу "Байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг хангах талаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө" боловсруулан Газрын даргаар батлуулав.<br>- Газрын зарим үйлчилгээ e-mongolia.mn-д холбогдсон талаар мэдээлэл бэлтгэн Газрын www.uda.ub.gov.mn цахим хуудас болон facebook хуудсанд байршуулсан. | |
| *Барилгын ажлын зөвшөөрөл олгох, чанар, аюулгүй байдлыг хангах гамшгаас хамгаалахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:* | | | | | | | |
| 2.22 | Нийслэлийн түр хоргодох орон байраар хангах албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох | - | Тодотгол 1 | 1 | 1 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/59 дүгээр захирамжаар баталсан хуваарийн дагуу Түр орон байраар хангах албаны нийт бүрэлдэхүүн, орон тооны бус штабын бэлтгэл бэлэн байдалд Нийслэлийн Засаг даргын нэрэмжит үзлэг, шалгалт 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулагдаж 81 албан хаагч оролцсон. Уг үзлэгээр албан хаагч нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйл, хувцасны жигдрэлт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийсэн байдал, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, сургалт, түр орон байр, хот байгуулалтын мэдээллийн сангийн бэлтгэл, бэлэн байдал зэрэг 17 үзүүлэлтээр Ажлын хэсэг шалгалт хийсэн бөгөөд 90% буюу А үнэлээ авсан.<br>- Газрын даргын 2022 оны А/19 дүгээр тушаалаар түр орон байраар хангах албаны Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн томилгоонд тодотгол хийж, бэлэн байдлыг хангуулсан. Зарлан мэдээллийн дохио дамжуулах бүдүүвчийг албаны хэмжээнд нарийвчлан гаргав. | 100 |
| 2.23 | Барилга, байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт /паспортжуулах/ төлбөртэй хэмжилт, судалгаа хийж, дүгнэлт гаргах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | 2022 оны хагас жилийн байдлаар 6 барилгад хэмжилт судалгаа хийж, төлөв байдлын дүгнэлт гарган, нийслэлийн төсөвт 5.4 сая төгрөгийн хөрөнгө оруулсан. | 100 |
| 2.24 | Барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулах | - | Сургалтын тоо | - | 1 | Барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын талаар Сууц өмчлөгчдийн холбоодын удирдах албан тушаалтнуудад сургалт зохион байгуулах хөтөлбөр боловсруулсан бөгөөд сургалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар болсон. | 30 |
| 2.25 | Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох | - | Үйл ажиллагаан | 100 | 100 | Засгийн газрын 213 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжүүлэх зөвшөөрөл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ы хэрэгжилт, хувь | | | олгох дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулан иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар нийт 467 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. Үүнд:<br>✓ Барилгын ажилд-230,<br>✓ Цахилгаан-195<br>✓ Буулгалтын ажилд-19,<br>✓ Инженерийн шугам сүлжээний угсралтын ажилд-23,<br>Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ сунгалт -59 хийгдсэн байна. | |
| *Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хүрээнд:* | | | | | | | |
| 2.26 | Нийслэлийн нутаг дэвсгэрт Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн ажлын даалгавар боловсруулах,<br>o | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | Улсын, Нийслэл, орон нутгийн сангийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах хүсэлтийг холбогдох байгууллагуудаас хүлээн авч **24** асуудлыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн .<br>Үүнд:<br>✓ Дулаан хангамжийн шугам сүлжээ - 6<br>✓ Цахилгаан хангамжийн шугам сүлжээ -2<br>✓ Ус хангамж ,ариутгах татуургын шугам -4<br>✓ Харилцаа холбооны шугам сүлжээ -2<br>Инженерийн бэлтгэл арга хэмжээний чиглэлээр-10 | 100 |
| 2.27 | Нийслэлийн нутаг дэвсгэрт Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн ажлын зураг төслийг хянах, зөвшилцөх, хэрэгжилтэд хяналт тавих; | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | Улаанбаатар хотын **9** дүүргийн 605 байршилд дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зөвшилцсөн. Үүнд:<br>✓ Дулаан хангамж **-99**<br>✓ Усан хангамж ариутгах татуурга **67**<br>✓ Цахилгаан хангамж - **330**<br>✓ Харилцаа холбоо- **90**<br>✓ Инженерийн бэлтгэл арга хэмжээ **19** | 100 |
| 2.28 | Хот дахин хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн инженерийн хангамжийн төлөвлөлтийн шийдлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын тооцоо | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган дахин барилгажуулах төслийн **15 төсөл арга** хэмжээний гадна инженерийн шугам сүлжээнд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэн 3036 айлын орон сууцны барилга баригдсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулан, холбогдох газруудад санал өгч шийдвэрлүүлэх, зураг төслийн даалгавар боловсруулан гүйцэтгэлийг хянан зөвшилцөх. | | | | | - Гэр хорооллыг дахин барилгажуулах төслийн хүрээнд **3 байршилд** ажлын зургийн даалгавар боловсруулсан.<br>- Гэр хорооллын дахин барилгажуулах төслийн **3 байршилд** төлөвлөлтийн шийдэл зөвшилцсөн.<br>- Гэр хорооллын дахин барилгажуулах төслийн **2 байршлын** барилгажилтын төсөлд гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэлд санал, зөвлөмж хүргүүлсэн. | 100 |
| *Хот дахин хөгжүүлэх зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:* | | | | | | | |
| 2.29 | Хот суурин газрын барилгажсан хэсэг, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөх, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах асуудлыг зохион байгуулж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган барилгажуулах төслийн хүрээнд дараах төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 11 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг баталж хүргүүлсэн.<br>- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн хүсэлтийг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, 5 байршилд архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг баталж хүргүүлсэн.<br>- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 08 дугээр сарын 31-ний өдрийн 08/22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон сууцны 7 дугаар нэгж хорооллын"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Сүхбаатар дүүргийн 9, 10, 11, 12-р хорооны нутаг дэвсгэрт, гэр хорооллын дахин төлөвлөлтийн К1,Е1,3 хэсэгчилсэн талбайн ажлын даалгаврыг боловсруулж, Нийслэлийн Ерөнхий архитектораар хянан батлуулж, Орон сууцны бодлогын газарт хүргүүлсэн. | 100 |
| *Дотоод хяналт, Хуулийн зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээний хүрээнд:* | | | | | | | |
| 2.30 | Газрын эрхлэн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, газрын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Газрын эрхлэн явуулж буй үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, газрын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай холбогдох дүрэм, журмын төслийг Нийслэлийн Засаг даргын 30 захирамжлалын баримт бичигт санал өгсөн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдох дүрэм, журмын төслийг шинээр боловсруулах, санал гаргах | | | | | | |
| 2.31 | Хот байгуулалтын талаар хууль, дүрэм, журам холбогдох баримт бичигт санал тусгаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөл, Хөрөнгө оруулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд санал өгсөн. | 100 |
| 2.32 | Байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой хот байгуулалтын гэрээ, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төсөлд оролцогч талуудын гэрээ байгуулах, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, дүгнэх асуудлыг зохион байгуулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл боловсруулж, барилга угсралтын ажил гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэхээр шалгарсан 22 төсөл хэрэгжүүлэгчийн нийт 775 гурван талт гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулан ажиллав.<br>- Төсөл хэрэгжүүлэгч гурван талт гэрээний үүргээ биелүүлсэн, шинээр баригдсан орон сууцаа Улсын комисст хүлээлгэн өгсөн "Кристал инженеринг" ХХК, "Алтан трейд" ХХК, "Асиан сити" ХХК төсөл хэрэгжүүлэгчийн 79 гэрээг дүгнэсэн. | 100 |
| 2.33 | Газрын хэмжээнд дотоод хяналтыг зохион байгуулж, үйл ажиллагаанд мониторинг хийх, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Газрын 2022 оны Дотоод хяналт, шалгалтын ажлын 10 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулж, Захиргааны зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар танилцуулав. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- Газрын даргаар батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон зөвшөөрөл олгосон барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээ, тохижилтын мэдээлэл хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд бүртгэсэн эсэх төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийг батлуулж, хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэв. Шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг Захиргааны зөвлөлд танилцуулахаар бэлтгэн ажиллаж байна.<br>- Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн ажил үйлчилгээ, албан хаагчдийн мэргэжил ур чадварын талаар гаргасан гомдлын дагуу хяналт, шалгалтын хийж, нийт 49 өргөдөл, гомдлын барилгын норм дүрэм хангасан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эсэх, шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж хариу өгч шийдвэрлэв. Үүнд:<br>✓ Авлигатай тэмцэх газрын 2,<br>✓ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 8,<br>✓ Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 9,<br>✓ Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5,<br>✓ Иргэн, хуулийн этгээдийн 25<br>- Газрын даргын захирамжлалын болон бусад захиргааны актад кодификаци хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд 38 Архитектур төлөвлөлтийн даалгавар болон загвар зурагт кодификаци хийв.<br>- Газрын даргын №Т2022/01 удирдамжийн дагуу зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд бүртгэгдсэн талаарх хяналт шалгалт хийв. | |
| **ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:** | | | | | | | |
| 3.1 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Бодлогын баримт бичгийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилт, 2022 оны хагас жилийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлын тэмдэглэл, танилцуулгын хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст 2022 оны 01/2276 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>- Захиргааны зөвлөлийн хурлаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хэлэлцүүлэн хагас жилийн байдлаар явцын хяналт шинжилгээ үнэлгээг хийн хурлын тэмдэглэл, танилцуулгын хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст албан бичиг болон mishig60@gmail.com цахим хаягаар хүргүүлэв.<br>- Нийслэлийн Засаг даргын Захирамжийн 2022 оны хагас жилийн хэрэгжилтийг 1,2 дугаар улирлын байдлаар гарган lmonitoring.ulaanbaatar.mn программаар тайлагнав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2 | Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дээд газраас ирсэн зөвлөмжийн дагуу боловсруулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст 2022 оны хагас жилийн үйл ажиллагааны тайланг тус тус тайлагнав. | 100 |
| 3.3 | Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | Тайлант хугацаанд байгууллагын http://uda.un.gov.mn цахим хуудсанд 12 төрлийн 120 мэдээ мэдээллийг шинэчлэн байршуулав. Үүнд:<br>✓ Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээ – 1<br>✓ Үйл ажиллагааны төлөвлөгөө – 10<br>✓ Санхүүгийн мэдээ – 10<br>✓ Мэргэжлийн зөвлөлийн хурлын мэдээ – 38<br>✓ Барилгын ажлын зөвшөөлийн гэрчилгээ олгосон мэдээ – 10<br>✓ Цаг үеийн мэдээ – 10<br>✓ Хүний нөөцийн мэдээ – 6<br>✓ Бүтэц, зохион байгуулалтын мэдээ – 11<br>✓ Тендерийн урилга – 2<br>✓ Ирсэн, явсан бичгийн мэдээ – 4<br>✓ Үйлчилгээний бүрдүүлэх материал – 23<br>- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн албан бичиг, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу "Байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө" боловсруулан газрын даргаар батлуулав.<br>- Газрын зарим үйлчилгээ e-mongolia.mn холбогдсон талаар мэдээлэл бэлтгэн байгууллагын www.uda.ub.gov.mn цахим хуудас болон facebook хуудсанд байршуулсан. | 100 |
| 3.4 | Газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, хүний нөөцийн ил тод байдлыг хангаж ажиллах | - | Үйл ажиллагаан ы хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 сарын 12-ны өдрийн "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" А/641 'дугээр захирамжаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгогдсон 34 албан хаагчийн зэрэг дэв, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | түүний нэмэгдлийг Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд https://hr.csc.gov.mn/hub/login.html, 2022 онд 29 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулж, 5 албан хаагчид шинээр зэрэг дэв олгогдсон.<br>- Төрийн захиргааны 82 албан хаагчаас 64 албан хаагч буюу 78% зэрэг дэвтэй байна.<br>- Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тооны судалгааг 2022 оны 01/652 дугаартай албан бичгээр хүргүүлж, газрын цахим хуудсанд тухай бүр байршуулан нээлттэй мэдээлэв.<br>- Газрын нийт албан хаагчдын цалин, нэмэгдлийг Хөдөлмөрийн дотоод журам заасны дагуу сүүлийн гурван жил дараалан "А" үнэлэгдсэн 21 албан хаагчид цалингийн шатлалыг алгасуулан, 3 албан хаагчийг ажилласан жилээр тус тус нэмэгдүүлж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 8 албан хаагчид журмын дагуу ахиулж, 11 албан хаагчид удаан жилийн нэмэгдлийг шинээр олгож, 64 албан хаагчийн зэрэг дэвийн, 4 албан хаагчийн ур чадварын нэмэгдлийг эрх бүхий байгууллагаас баталсан шийдвэр, холбогдох журмын дагуу тус тус нэмэгдүүлж Газрын даргын 2022 оны Б/06, Б/07 дугаар тушаалаар тус тус батлуулав.<br>- Нийслэлийн Онцгой комиссын шуурхай штабын Орон зайн дүн шинжилгээний багт ажиллаж байгаа 2 албан хаагчид 2022 оны эхний 3 сарын илүү цагийн нэмэгдэл, нийслэлийн удирдлагаас тусгайлан өгсөн үүрэг даалгаврын дагуу 2022 оны 01 дүгээр сарын 8, 9, 15-ны өдөр, 2 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд ажилласан нийт 77 албан хаагчид Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын нэмэгдэл цалин хөлсийг тус тус олгов.<br>- Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 9 албан хаагчид 1,750,000 төгрөгийн тэтгэмж олгов. Мөн Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 68 албан хаагчийн 16 хүртэлх насны 135 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдэд бэлэг авахад зориулж 5.600.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн.<br>- Засгийн газрын 2022 оны 192, 194 дүгээр тогтоолын дагуу "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 27 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ад орсон нэмэлт, өөрчлөлт, Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-нд орсон өөрчлөлт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/641 дүгээр захирамжаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл"-ийн дагуу албан хаагчдын албан тушаалын цалин, нэмэгдлийг Газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн Б/57 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. | |
| 3.5 | Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөн, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, өр авлага үүсгэхгүй ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль бусад хууль, дүрэм журмын хүрээнд төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, хөрөнгө оруулалтын дансны мэдээ, барьцаа дансны мэдээ, нэмэлт санхүүжилтийн дансны мэдээ төсөв санхүүтэй холбоотой 5 бүлгийн 9 мэдээ тайланг хугацаанд нь байршуулж, шилэн дансны хөтлөлт, баяжилтыг хийж ажиллав. | 100 |
| 3.6 | Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж, төсөвт байгууллагын өөрийн орлогыг хуваарийн дагуу хангаж биелүүлэх | 110.0 сая төгрөг | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - 2022 оны хагас жилийн байдлаар 1.136,699,0 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, 71.767,8 мянган төгрөгийн орлого олж 592.866,3 мянган төгрөг зарцуулаад байна.Орлого:<br>✓ Хаяг дугаар – 40.619,600 мянган төгрөг<br>✓ Лавлагаа – 128,6 мянган төгрөг<br>✓ Гэрчилгээ – 628,6 мянган төгрөг<br>✓ Тодорхойлолтын үнэ – 767,1 мянган төгрөг<br>✓ Тендер – 5.400,0 мянган төгрөг<br>✓ Зургийн үнэ – 9.480,1 мянган төгрөг<br>✓ Барилгын чанарын дүгнэлт 5.403,8 мянган төгрөг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Барилгын ажлын эхлүүлэх зөвшөөрөл-9.340,0 төгрөг | |
| 3.7 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 захирамжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж тайлагнаж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжаар 2022 оныг "Хотын иргэний жил" болгон зарласан зорилтот жилийн хүрээнд Газрын хэмжээнд "Хотын иргэний жил"-д хэрэгжүүлэх 4 зорилт, 27 арга хэмжээг хэрэгжүүлж, ажиллах төлөвлөгөөг Газрын даргаар 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр батлуулав. Төлөвлөгөөний биелэлтийг хагас жилээр гарган Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 6 дугаар сарын 17-ны өдрийн 01/2321 дугаартай албан бичгээр тайлагнав. | 100 |
| 3.8 | Авлигатай тэмцэх хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:<br>- Газрын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж Газрын даргын 2022 оны А/09 дүгээр тушаалаар "Мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалт"-ыг шинэчлэн баталсан. Тушаалаар ТЗ-5 ангиллын 50 албан хаагчийг хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахаар шийдвэрлэсэн.<br>- Шинээр болон албан тушаал нэр дэвшин томилогдсон 11 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг цахимаар мэдүүлж, Авлигатай тэмцэх газраар хянуулав.<br>- Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг 1, 2 тайлан мэдээ, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэлийн хамт цахимаар Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (erp.ulaanbaatar.mn), batorgilt82@gmail.com цахим хаягаар холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.<br>- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Газраас 2022 онд хэрэгжүүлэх Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн тайланг Нийслэлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засаг даргын Тамгын газарт албан бичгээр хүргүүлэв.<br>- Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг 2021, 2021* гаргасан 60, албан тушаалд томилогдсоноос хойш Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг 2020* мэдүүлсэн 20, их хэмжээний өөрчлөлт 2020+ мэдүүлсэн 4, нийт 84 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч, баталгаажуулав. | |
| 3.9 | Хууль, шүүхийн байгууллагад хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа нийслэлийн Засаг дарга болон газрын удирдлагын шийдвэртэй холбоотой эрх зүйн маргаанд итгэмжлэлээр оролцох | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Хууль, шүүхийн байгууллагад хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа нийслэлийн Засаг дарга болон газрын удирдлагын шийдвэртэй холбоотой 86 эрх зүйн маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцов. | 100 |
| 3.10 | Байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төслийг хянах, бүрдлийг хангах, бүртгэл хөтлөх, хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээг дүгнэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | Хот байгуулалт дотоод үйл ажиллагааны чиглэлээр 21 гэрээг байгуулсан бөгөөд хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулав. | 100 |
| 3.11 | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын дагуу бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэр, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт болон байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, хяналт тавих | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Бодлогын баримт бичгийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилт, 2022 оны хагас жилийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хурлын тэмдэглэл, танилцуулгын хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст 2022 оны 01/2276 дугаартай албан бичгээр хүргүүлэв.<br>- Захиргааны зөвлөлийн хурлаар хууль тогтоомжийн 2022 оны хагас жилийн хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээ үнэлгээг хийн хурлын тэмдэглэл, танилцуулгын хамт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст албан бичгээр mishig60@gmail.com цахим хаягаар хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд улирал хагас жилээр хяналт, шинжилгээ-үнэлгээг 2 удаа хийж Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 02-01/938, 6 дугаар сарын 28-ны өдрийн 01/2449 дугаартай албан бичгээр тус тус тайлагнав.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 5 дугаар зүйлийг үндэслэн алба, хэлтсүүдийн 1,2 дугаар улирлын тайланг хүлээн авч танилцан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн Захиргааны зөвлөлийн 09 дүгээр хуралд танилцуулан цаашид тайлан мэдээ гаргахдаа анхаарах асуудлуудын талаар алба, хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлсэн. | |
| 3.12 | Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийх, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | 100 | - Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2021 онд хийгдсэн "Авлига, хүнд суртлыг таслан зогсоох арга хэмжээ авах, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн хяналт, шалгалт"-ын дүгнэлтийн дагуу цаашид авах арга хэмжээний саналын дагуу 23 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаанд мөрдөж, хэрэгжилтийн мэдээг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт заасан хугацаанд хүргүүлэв.<br>- Нийслэлийн Дотоод Аудитын албанаас 2021 онд хийгдсэн Газрын 2019-2021 оны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтын ажлын тайлангийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг 2022 оны 03/10/1129 дугаартай албан бичгээр хүргүүлэв. | 100 |
| 3.13 | Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөл болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах | - | Сургалтад хамрагдсан цаг /1 албан хаагч/ | 1 албан хаагчийн сургалтад хамрагдсан цаг /дунджаар 60 цаг/ | 1 албан хаагчийн сургалтад хамрагдах цаг /дунджаар 40 цагаас | - Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, "Нийслэлийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Сургалт, судалгааны хөгжлийн төв болон бусад нийслэлийн холбогдох байгууллагаас зохион байгуулсан "Төрийн албаны албаны зөвлөлийн аргазүйн сургалт", "Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж болон eDoc системийн ашиглалтыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багагүй байх / | сайжруулах чиглэлээр цахим сургалт", "Өргөдөл, гомдлын асуудал хариуцсан албан хаагчдын ур чадварыг дээшлүүлэх мэргэжил арга зүйн сургалт" зэрэг 25 удаагийн сургалтад (цахимаар 31, танхимын 15) нийт 299 албан хаагч хамрагдав.<br>- Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт үнэлгээ "Алсын хараа – 2050" сургалтад 2 албан хаагч хамрагдаж үнэмлэх гардан авав.<br>- Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад Газрын дарга хамрагдав. Нийт 48 удаагийн сургалтад (цахимаар 32, танхимын 16) нийт давхардсан тоогоор 302 албан хаагч хамрагдав. | |
| 3.14 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах | | Шийдвэрлэлтийн хугацаа /хоногоор/ | 9 хоног | 8 хоног | - 2022 оны хагас жилийн байдлаар нийт 2318 албан бичиг ирсэн. Үүнээс:<br>✓ хугацаанд нь хариу өгч шийдвэрлэсэн – 1952<br>✓ хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – 12<br>✓ шийдвэрлэх хугацаандаа судлагдаж байгаа – 133<br>Албан бичгийн шийдвэрлэлтийн хувь 99,64 хувь, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног байна.<br>Байгууллагаас нийт явсан 2539 бичгийг стандартын дагуу хэвлэмэл хуудсанд буулгаж, гараар дугаарлан үг үсгийн алдааг хянаж, албан хаагчдын цахим баримт боловсруулалтад хяналт тавьж ажиллав.<br>Гэрээт шуудангаар - 992 бичгийн хаяг, дугаарыг гараар бичиж явуулсан байна.<br>- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц: Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц:<br>Нийт 1163<br>✓ Судалж байгаа - 79<br>✓ Шийдвэрлэсэн -1084<br>✓ Шийдвэрлэлт - 93.21%<br>✓ Дундаж хугацаа- 11 хоног 22 цаг байна.<br>Хариу өгсөн байдлыг авч үзвэл:<br>✓ Утсаар хариу өгсөн -556<br>✓ Албан бичгээр хариу өгсөн -426<br>✓ Мессежээр хариу өгсөн -102<br>Шийдвэрлэсэн байдал:<br>✓ Иргэний талд шийдсэн - 599 | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Боломжгүй хариу өгсөн- 305<br>✓ Бусад -164 | |
| 3.15 | Албан хаагчдын баримт бичгийн боловсруулалтыг сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулах | - | Сургалт зохион байгуулсан эсэх | 2 | 3 | - Шинээр орсон албан хаагчдад зориулж www.erp.ulaanbaatar.mn–edoc системээр баримт боловсруулах, ирсэн бичгийн шийдвэрлэлтэд анхаарах асуудлууд сэдвээр 1 удаа сургалт зохион байгуулав. | 30 |
| 3.16 | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100 | - | - Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг архивд хүлээлгэн өгөх хуваарийг Газрын даргаар батлуулан, байнга хадгалах 532, түр хадгалах 156, 70 жил хадгалах 3, тусгай төрлийн 962 баримтыг нягтлан шалгаж, данс бүртгэлийг үүсгэн байгууллагын архивд хүлээн авав.<br>- Барилгын хувийн хэрэгт нөхөн бүрдүүлэх шаардлагатай 42 хувийн хэргийг нөхөн бүрдүүлэв.<br>- Албан хэрэгцээнд 38 албан хаагчид 106 архивын баримтыг түр ашиглуулан, бүртгэл хөтлөв.<br>- Нийслэлийн Архивын газрын заавар зөвлөмжийн дагуу 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд барилгын 2007-2017 оны 6557 хувийн хэрэг, зураг төсөл, техникийн 2002-2020 оны 438 баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалтыг хийж, 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 3 дугаар хурлаар оруулан баталгаажуулж, Нийслэлийн Архивын газрын сан хөмрөгт шилжүүлэв.<br>- Газрын даргын 2021 оны үндсэн үйл ажиллагаатай холбоотой "А" тушаал 44, хүний нөөцтэй холбоотой "Б" тушаал 105-ыг бүрэн цахимжуулж, архивлав. | 100 |
| ***ДӨРӨВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:*** | | | | | | | |
| 4 | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн мэдээлэл, дэд бүтэц, барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, ухаалаг технологийг нэвтрүүлэн шийдвэрлэнэ. | | | | | | |
| 4.1 | Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд I-UP мэдээллийн цонхыг тогтмол ажиллуулах | - | I-UP мэдээллийн цонхонд мэдээ мэдээлэл байршуулсан тоо | 4 | 6 /Өссөн дүнгээр/ | - Барилгад хаяг дугаар олгох, мэдээллийн санд бүртгэх, Архитектур төлөвлөлтийн даалгавар олгох, Барилгын ажлын эхлүүлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний хүсэлтийг цахимаар илгээх зааврын I-UP видео эвлүүлэг хийсэн.<br>- 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс байгууллагын веб хуудсанд Барилгын ажлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвшөөрлийн гэрчилгээ олгосон иргэн, хуулийн этгээдийн мэдээ мэдээллийг 14 хоногт тутамд шинэчлэн **6** удаа байршуулсан.<br>- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинэчлэн барилгажуулах ажлын явцын танилцуулга, тулгамдаж байгаа асуудлын талаар танилцуулга бэлтгэн мэдээллийг байршуулав.<br>- НИТХТ-ийн 2015 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам"-ын танилцуулгыг байршуулав.<br>- Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг УИХ-аар батлагдахаар I-UP мэдээллийн цонхонд байршуулахаар төлөвлөж байна.<br>- 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон иргэн, хуулийн этгээдийн мэдээ мэдээллийг 14 хоногт тутамд шинэчлэн оруулж байна. | |
| 4.2 | Хот байгуулалтын үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаан захиргааны сөрөг акт гарсан тохиолдолд бүртгэлжүүлж мэдээлж ажиллах. | - | Сөрөг актын тоог бууруулсан байдал: Архитектур төлөвлөлтийн даалгаврын тоо | 22 | 20 /Сөрөг актын тоог 5 хувиар бууруулсан байна/ | Захиргааны сөрөг акт гарах тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу эрх ашиг нь хөндөгдөж буй 12 иргэн, хуулийн этгээдэд сонсох ажиллагааг явуулж 12 байршилд захиргааны актыг түдгэлзүүлсэн шийдвэр гарсныг мэдээлж ажиллав. Үүнд:<br>- Архитектур төлөвлөлтийн даалгавар-3<br>- Загвар зураг - 3<br>- Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ-8 | 100 |
| | | | Загвар зургийн тоо | - | 20 /Сөрөг актын тоог 5 хувиар бууруулсан байна/ | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Барилгын ажлын зөвшөөрлийн тоо | - | 20 /Сөрөг актын тоог 5 хувиар бууруулсан байна/ | | |
| 4.3 | Архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх хүсэлтийн тоог бууруулах | - | Эргэлтийн цэг солих тоог бууруулсан хувь | - | 5 хувиар бууруулсан байна. | - Архитектур төлөвлөлтийн даалгаврын схем зургийн эргэлтийн цэгийн солбицол өөрчлүүлэх 29 хүсэлт ирснээс 23 хүсэлтийг шийдвэрлэж, 6 хүсэлт нь батлагдсан загвар зургийг өөрчилсөн байсан тул буцаасан. | 100 |
| 4.4 | Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах | - | 22 үйлчилгээг цахимжуулсан байдал, тоо | 11 үйлчилгээ цахимжсан | 5. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/60 дугаар тушаалаар "Иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний үр дүнг бодитой үнэлж дүгнэх, үйлчилгээг дахин загварчилж хүнд суртал, чирэгдлийг арилгаж эрх зүйн орчныг боловсронгуй болгох" зорилго бүхий ажлын хэсэг байгуулагдаж, тус ажлын хэсэгт газрын 7 төлөөлөл орж ажиллаж байна. Ажлын хэсгийн гишүүд дараах ажлыг хийж мэдээллийг Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлсэн. Үүнд:<br>✓ "Онлайн бизнес төв"-ийн зөвлөх үйлчилгээ гүйцэтгэгч "Систем арт винчерс" ХХК-ийн холбогдох албан хаагчидтай хамтарсан уулзалтыг зохион байгуулж, Газрын өдөр тутмын үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн.<br>✓ Газраас иргэн, хуулийн этгээдэд өдөр тутамдаа үзүүлдэг 22 үйлчилгээний өнөөгийн шат дамжлага, үйлчилгээний процесс, бүрдүүлэх материалын жагсаалт, эрх зүйн үндэслэл, хэд хоногт шийдвэрлэдэг талаарх мэдээлэл,<br>✓ Мөн 22 төрлийн үйлчилгээг Барилгын зөвшөөрөлтэй холбоотой болон Бусад гэсэн 2 бүлэг 8 төрөл болгон нэгтгэх, дахин зохион байгуулах саналыг схем хэлбэрээр гаргаж,<br>✓ Ажлын хэсгийн хүрээнд шийдвэрлэх арга зам, үйл ажиллагааг сайжруулахад боломжтой | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Бүрдүүлэх материалын жагсаалтыг багасгах саналыг үйлчилгээ тус бүрээр гарган, *Тухайлбал*, Барилга барих хүсэлт илгээхэд бүсээсээ хамаараад 8-9 төрлийн баримт бичиг бүрдүүлдэг байсныг 5 төрөл болгож, Загвар зураг батлах үйлчилгээнд 10 төрлийн баримт бичиг шаарддаг байсныг 3 төрөл, Шугам сүлжээний зураг зөвшилцөхөд 8 төрлийн баримт бичиг бүрдүүлдэг байсныг 5 төрөл, Тэг тэнхлэг мэдээллийн санд бүртгэхэд 6 төрлийн баримт бичиг бүрдүүлдэг байсныг 3 төрөл болгох саналыг тус тус гаргаж бүрдүүлэх материалыг 50 хувиар бууруулах санал,<br>✓ Тус байгууллага нь төрийн нэгдсэн сүлжээ ХУР-д холбогдсон тохиолдолд дээрх бүрдүүлэх баримт бичгүүд дахин 50 хувиар багасах боломжтой талаарх санал.<br>- Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээнд холбогдох болон байгууллагаас үзүүлдэг үзүүлдэг бусад үйлчилгээг e-mongolia.mn-д холбох талаар E-Mongolia академийн холбогдох мэргэжилтнүүдтэй уулзан холбогдох санал солилцсон.<br>- Төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-Mongolia системд Загвар зураг батлах үйлчилгээг оруулахтай холбоотойгоор зураг зөвшилцөх албан хаагчдын холбогдох мэдээллийг нэгтгэн E-Mongolia академийн хариуцах мэргэжилтэнд хүргүүлсэн. | |
| 4.5 | Орон сууцны барилгад дур мэдэн хийсэн зориудын өөрчлөлтөөс гамшгийн дараа үүсэж болох сөрөг нөлөөллийн талаар иргэдэд сургалт явуулах, таниулах материал бэлдэх, сурталчлах | - | Сургалтын тоо | 3 | 2 | Иргэдэд орон сууцны барилгад дур мэдэн хийсэн зориудын өөрчлөлтөөс гамшгийн дараа үүсэж болох сөрөг нөлөөллийн талаарх сургалтыг газар дээр нь зохион байгуулан ажиллахаар хөтөлбөр боловсруулсан. Хөтөлбөрийн дагуу сургалтыг 3 дугаар улиралд хийхээр төлөвлөсөн. | 30 |
| 4.6 | Инженерийн шугам сүлжээний батлагдсан трассыг хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж оруулах | | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2020 онд 77667 м шугам сүлжээний трасс | 100 | - Газрын даргын 2020 оны А/85 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем дэх барилгын мэдээллийн сангийн төлөвлөгдсөн хэсгээс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэдээллийн санд оруулсан | | давхардсан, төлөвлөлт өөрчлөгдсөн, хүчингүй болсон зэрэг дэд бүтцийн төлөвлөлтийн трассыг тулгалтын ажлыг гүйцэтгэсэн.<br>- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа **82205 метр** инженерийн шугам сүлжээний трассыг хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. | |

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч ............................ /Д.Сумъяабазар/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

*Тэмдэг* ..............................

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газрын дарга ............................ /Ц.Тулга/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

............................